



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/265

Булган сум

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх 2025 оны дархлаажуулалт зохион байгуулах тухай” А/124 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Тэшиг, Сэлэнгэ суманд гоц халдварт үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 18 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Гоц халдварт үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.


3.Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ДЛПҮРЭВ-ОЧИР



04
A/265
Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 23-ны/ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ГОЦ ХАЛДВАРТ ҮХРИЙН АРЬС ТОВРУУТАХ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

| д/д | Сумын нэр | Хамрагдах малын тоо | | | Шаардагдах тун | Шингэлэгч |
|-----|-------------|---------------------|---------------|---------------|----------------|----------------|
| | | Үхэр | Тугал | Нийт дүн | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Тэшиг | 26,459 | 8,132 | 37,591 | 37,600 | 75,200 |
| 2 | Сэлэнгэ | 29,921 | 8,273 | 38,194 | 38,200 | 76,400 |
| | Бүгд | 56,380 | 16,405 | 72,785 | 75,800 | 151,600 |